



ОРОН НУТГИЙН ОРЧИН  
ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

# Орон нутгийн орчин

- Орон нутгийн орчин гэдэгт хүмүүсийн ажиллаж, сурч, амьдарч буй аймаг, хот, сум, дүүрэг, баг, хорооны хүмүүс хоорондын харилцаа, нийгмийн бүлэг, байгууллагуудын хүрээг ойлгож болно.
- Орон нутаг бүр хоорондоо ялгаатай байдаг



# Хувь хүн ба нийгмийн хамаарал

- Яагаад хувь хүмүүс хоорондоо харилцаж, хоршин амьдардаг вэ?
- Хүн тус бүр хувь хувиа бодоод, салангид амьдарч болохгүй гэж үү?

# Э.Дюркгеймийн

- Энэ талаар судалгаа хийсэн нэрт социологич Э.Дюркгеймийн үзсэнээр хувь хүмүүс, өрх гэрүүд хоршин амьдрах шалтгаан нь хоёр үндсэн хэв шинжтэй байдаг.

- 



- **Нэгд, хүмүүс адил төстэй зүйлээрээ** буюу эрхэлж буй аж ахуйн хэвшлээрээ, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээрээ, мөн сэтгэл санаагаараа адилсаж **хоршин амьдардаг**. Үүнийг тэрээр **“механик эв нэгдэл”** гэж нэрлэсэн байдаг. Энэ нь түүхийн эрт үед болон жижиг орон нутгийн хүрээнд ихэвчлэн илэрдэг.

- **Хоёрт, хүмүүс өөртөө байхгүй зүйлийг бусдаас авах, солилцоо хийх зорилгоор хоорондоо байнга харилцдаг.**

- Хүмүүсийн дунд хамаарал үүснэ
- Үүнийг тэрээр “органик нэгдэл” гэж нэрлэсэн байна.
- Хөдөлмөрийн хуваарь улам бүр мэргэшин ялгарах тусам нийгэм механик эв нэгдлээс органик эв нэгдэл рүү шилждэг.
- Хүмүүсийн амьдралд орон нутгийн байгууллагууд, гэр бүл, төрөл садан, орц, хот айл зэрэг нийгмийн бүлгүүд чухал үүрэгтэй.

## Хувь хүний хэрэгцээ

- Америкийн сэтгэл судлаач А.Маслоу 1954 онд хэвлүүлсэн “Сэдэл ба хувь хүн” хэмээх судалгааны бүтээлдээ хүнд олон хэрэгцээ байдаг ч тэдгээр нь дараах 5 үндсэн эрэмбээр шаталсан байдаг гэж үзжээ



Хамгийн дээд шатанд хүн хувийн онцлог, боломжоо бүрэн нээх, чадавхиа бүрэн хэрэгжүүлэх, нийгэмдээ хувь нэмрээ оруулах зэрэг хэрэгцээг илүүтэй хангахыг зорьдог ажээ.



- Тэрээр А.Эйнштэйн, М.Ганди, Б.Спиноза, Т.Жефферсон зэрэг алдар хүндтэй, амжилтад хүрсэн хүмүүсийн амьдралын замналыг судалсны эцэст өөрийн онолыг дэвшүүлжээ.

## Дүгнэлт

- Би дний амьдарч буй орон нутагт байгаа олон янзын бүлэг, байгууллагууд нь хувь хүмүүсийн олон янзын хэрэгцээг хангах үүрэг гүйцэтгэж байдаг. Хүмүүсийн хэрэгцээ өөрчлөгдөж байдаг учраас эдгээр бүлэг, байгууллагууд зэрэгцэн өөрчлөгдөх шаардлагатай болдог. Хүмүүсийн хэрэгцээ зохистойгоор хангагдаж буй эсэх нь орон нутагт олон янзын асуудал үүсэх нэгэн шалтгаан болдог.